



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/01/-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор/аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 141

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Сангийн яамны 2024 оны 02 дугаар сарын 6-ны өдрийн 10/683 тоот албан бичгийн хавсралтаар Төсвийн тухай хуулийн дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийг ирүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,362.9 сая төгрөг буюу 81 хувьтай байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөснөөс 290.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 7 зорилтын хүрээнд 77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын ИТХ-аас биелэлтийг 91 хувь гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702700449

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,613,571.7	1,914,595.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,830,310.1	2,011,348.0
Нийт хөрөнгийн дүн	3,443,881.8	3,925,943.8
Нийт өр төлбөрийн дүн	38,430.0	44,151.5
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,405,451.8	3,881,792.4
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,443,881.8	3,925,943.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	2,199,949.7	1,940,476.8
Үйл ажиллагааны зардлын дүн	1,683,701.7	1,018,936.0
Үйл ажиллагааны үр дүн	516,248.0	921,540.7
Үйл ажиллагааны бус зардлын дүн	3,589,377.2	445,200.2
Үйл ажиллагааны нийт үр дүн	(3,073,129.3)	476,340.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Өмчид гарсан өөрчлөлт	6,645,784.8	3,405,451.8
Тайлант оны үр дүн	(3,073,129.3)	476,340.5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(167,203.7)	
Эцсийн үлдэгдэл	3,405,451.8	3,881,792.3
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,123,269.5	1,692,267.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,581,259.8	866,936.6
Үйл ажиллагааны ЦМГ	542,009.7	825,330.4
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(462,470.6)	(474,688.3)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	(98,000.0)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	79,539.0	252,642.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	370,068.7	449,607.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	449,607.8	702,250.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,188,700.8	1,362,940.2
Урсгал зардал	727,194.2	828,047.4
Хөрөнгийн зардал	461,506.6	436,892.7
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,220,022.7	1,524,671.8
Орон нутгийн төсвөөс	1,165,583.4	1,352,397.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	54,439.3	172,274.4

Гурав. Аудитын илрүүлэлт:

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, нэгтгэгддэг нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 1,206,774.9 мянган төгрөгийн 9 алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан.

Аудитаар залруулагдаагүй нийт 28,041.2 мянган төгрөгийн 5 зөрчил илрүүлснээс 17,541.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,500.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн ба сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайланд буруу тусган илэрхийлсэн 1,657.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 10,237.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайланд буруу тусган илэрхийлсэн 48,999.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,103.2 мянган төгрөгийн 3 зөрчил илрүүлж 7,303.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,799.9 мянган төгрөгийн 2 заалт зөрчил арилгах, давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар санхүүгийн тайланд буруу тусган илэрхийлсэн 1,156,117.3 мянган төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй нийт 10,500.0 мянган төгрөгийн 2 зөрчил илрүүлснээс 10,500.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Албан шаардлага

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд малын тоо толгойн албан татварын орлого 9,770.0 мянган төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

730.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Алтай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 19 дугаар тогтоолыг зөрчсөн эрх ба үүрэг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр ханган ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2.Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй нийт 17,541.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, 17,541.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгаж цаашид давтан гаргахгүй байх 1 заалт албан шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д ""төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.3 санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.6.1-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нэгжийнхээ өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, үр дүнг агентлагийн даргын өмнө хариуцна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллэийн нэгтгэл:
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан				Залруулаагүй	
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Дүн		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын Засаг даргын Тамгын газар	4	48,999.7			4	48,999.7	4	48,999.7				
Алтай сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	1,657.9			1	1,657.9	1	1,657.9				
Дүн	5	50,657.6	0	-	5	50,657.6	5	50,657.6				

/мянган төгрөгөөр/

Үүнээс



Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	2	10,500.0	-	-	2	10,500.0	-	-
Алтай сумын Засаг даргын Тамгын газар	2	7,303.3	1	7,303.3	1	-	-	-
Алтай сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	10,237.9	1	10,237.9	-	-	-	-
Дүн	5	28,041.2	2	17,541.0	3	10,500.0	-	-

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын Засаг даргын Тамгын газар	1	3,799.9	-	-	1	3,799.9	-	-
Дүн	1	3,799.9	-	-	1	3,799.9	-	-

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо						Санал дүгнэлтийн хэлбэр						
		Аудитад хамрагдах						Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөөс татгалзсан	
		2	3	4	5	6	7	8	9					10
A	1													
1	Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
2	Алтай сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	Алтай сумын Засаг даргын Тамгын газар	1	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
4	Алтай сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Алтай сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
6	Алтай сумын Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	1	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	6	2	4	-	-	2	4	-	2	-	2	-	-